



**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**



**“БАГИЙН НИЙТИЙН ХУРЛААР БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ
БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭЛЭЛЦҮҮЛСЭН
БАЙДАЛД ҮНЭЛГЭЭ” ХИЙХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Захиалагч: Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам

Санхүүжүүлэгч: Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

Зөвлөх: М.Энхмэнд

Улаанбаатар хот

2017-02-17

Агуулга

Талархал.....	3
Товчилсон үгийн жагсаалт.....	4
Зургийн жагсаалт.....	5
Графикийн жагсаалт.....	6
Хүснэгтийн жагсаалт.....	7

Нэг. Өнөөгийн байдал.....	8
---------------------------	---

- 1.1. Судалгааны зорилго
- 1.2. Судалгааны хамрах хүрээ
- 1.3. Судалгааны арга зүй

Хоёр. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг 2012-2016 оны хооронд багийн нийтийн хурлаар хэлэлцүүлсэн байдал.....	9-10
--	------

2.1. Архангай аймаг.....	11-12
2.2. Баян-Өлгий аймаг.....	13-14
2.3. Баянхонгор аймаг.....	15-16
2.4. Булган аймаг.....	17-18
2.5. Говь- Алтай аймаг.....	19-20
2.6. Дархан уул аймаг.....	21-22
2.7. Дорноговь аймаг.....	23-26
2.8. Дорнод аймаг.....	27-29
2.9. Дундговь аймаг.....	30-32
2.10. Завхан аймаг.....	33-33
2.11. Орхон аймаг.....	34-35
2.12. Өвөрхангай аймаг.....	36-38
2.13. Өмнөговь аймаг.....	39-40
2.14. Сүхбаатар аймаг.....	41-43
2.15. Сэлэнгэ аймаг.....	43-45
2.16. Төв аймаг.....	46-51
2.17. Увс аймаг.....	52-53
2.18. Улаанбаатар хот.....	54-56
2.19. Ховд аймаг.....	57-58
2.20. Хөвсгөл аймаг.....	59-59
2.21. Хэнтий аймаг.....	60-62

Гурав. Дүгнэлт, зөвлөмж.....	63-70
------------------------------	-------

- 3.1.1. Төсөл хэрэгжсэн аймаг, сум
- 3.1.2. Ашигт малтмалын төрөл
- 3.1.3. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргааны санал
- 3.1.4. Багийн Нийтийн Хурлын ирц
- 3.1.5. Багийн Нийтийн Хурлаас гарсан санал, хүсэлт
- 3.2. Зөвлөмж

Дөрөв. Шинэчлэн найруулах болон нэмэлтээр оруулах эрх зүйн актын төсөл..... 71

Тав. Хавсралт..... 72-76

- 5.1. Нийтлэг шаардлага хангаж буй санал, тэмдэглэлийн хуулбар
- 5.2. Нийтлэг шаардлага хангахгүй санал, тэмдэглэлийн хуулбар
- 5.3. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийсэн эрх бүхий аж ахуйн нэгжийн жагсаалт

Товчилсон үгийн жагсаалт

1. АБОГ	Аймгийн Байгаль орчны газар
2. АЗД	Аймгийн Засаг дарга
3. АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
4. АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
5. БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
6. БЗД	Багийн Засаг дарга
7. БОННУ	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ
8. БИНХ	Багийн Иргэдийн Нийтийн Хурал
9. ДЗД	Дүүргийн Засаг дарга
10. ИНХ	Иргэдийн нийтийн хурал
11. ИНХД	Иргэдийн нийтийн хурлын дарга
12. ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
13. ИТХД	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга
14. СЗД	Сумын Засаг дарга
15. УИХ	Улсын Их Хурал
16. УСХ	Үндэсний Статистикийн Хороо

Зургийн жагсаалт

1. Зураг 1. Архангай аймаг.....	11
2. Зураг 2. Баян-Өлгий аймаг.....	13
3. Зураг 3. Баянхонгор аймаг.....	15
4. Зураг 4. Булган аймаг.....	17
5. Зураг 5. Говь- Алтай аймаг.....	19
6. Зураг 6. Дархан уул аймаг.....	21
7. Зураг 7. Дорноговь аймаг.....	23
8. Зураг 8. Дорнод аймаг.....	27
9. Зураг 9. Дундговь аймаг.....	30
10. Зураг 10. Завхан аймаг.....	32
11. Зураг 11. Орхон аймаг.....	34
12. Зураг 12. Өвөрхангай аймаг.....	36
13. Зураг 13. Өмнөговь аймаг.....	38
14. Зураг 14. Сүхбаатар аймаг.....	41
15. Зураг 15. Сэлэнгэ аймаг.....	44
16. Зураг 16. Төв аймаг.....	46
17. Зураг 17. Увс аймаг.....	52
18. Зураг 18. Улаанбаатар хот.....	54
19. Зураг 19. Ховд аймаг.....	57
20. Зураг 20. Хөвсгөл аймаг.....	59
21. Зураг 21. Хэнтий аймаг.....	60
22. Зураг 22. Уул уурхайн төслийн тоо /2012-2016/.....	63

Графикийн жагсаалт

1. График 1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан тайлангийн тоо 2012-2016.....	9
2. График 2. Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, жилийн эцсийн байдлаар, 2008-2016.....	10
3. График 3. Нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж.....	10
4. График 4. Ашиглаж эхэлсэн ордуудын ашигт малтмалын төрөл	64
5. График 5. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргааны саналыг гаргасан субъектүүд.....	64
6. График 6. Багийн нийтийн хурал болсон газрууд.....	65
7. График 7. Багийн нийтийн хурлын ирцийг, хуулийн шаардлагатай харьцуулж үзэхэд.....	66
8. График 8. Багийн Нийтийн Хурлаас гарсан санал, хүсэлт.....	68

Хүснэгтийн жагсаалт

1. Хүснэгт 1. Хуралдааны ирц /Архангай аймаг/.....	11
2. Хүснэгт 2. Уул уурхайн төсөл /Архангай аймаг 2012-2016/.....	12
3. Хүснэгт 3. Хуралдааны ирц /Баян-Өлгий аймаг/.....	13
4. Хүснэгт 4. Уул уурхайн төсөл /Баян-Өлгий аймаг 2012-2016/.....	14
5. Хүснэгт 5. Хуралдааны ирц /Баянхонгор аймаг/.....	15
6. Хүснэгт 6. Уул уурхайн төсөл /Баянхонгор аймаг 2012-2016/.....	16
7. Хүснэгт 7. Хуралдааны ирц /Булган аймаг /.....	17
8. Хүснэгт 8. Уул уурхайн төсөл /Булган аймаг 2012-2016/.....	18
9. Хүснэгт 9. Хуралдааны ирц /Говь- Алтай аймаг/.....	19
10. Хүснэгт 10. Уул уурхайн төсөл /Говь- Алтай аймаг 2012-2016/.....	20
11. Хүснэгт 11. Хуралдааны ирц /Дархан уул аймаг/.....	21
12. Хүснэгт 12. Уул уурхайн төсөл /Дархан уул аймаг 2012-2016/.....	22
13. Хүснэгт 13. Хуралдааны ирц /Дорноговь аймаг/.....	23
14. Хүснэгт 14. Уул уурхайн төсөл /Дорноговь аймаг 2012-2016/.....	24
15. Хүснэгт 15. Хуралдааны ирц /Дорнод аймаг /2012-2016/.....	27
16. Хүснэгт 16. Уул уурхайн төсөл /Дорнод аймаг 2012-2016/.....	28
17. Хүснэгт 17. Хуралдааны ирц /Дундговь аймаг/.....	30
18. Хүснэгт 18. Уул уурхайн төсөл /Дундговь аймаг 2012-2016/.....	31
19. Хүснэгт 19. Хуралдааны ирц /Завхан аймаг/.....	33
20. Хүснэгт 20. Уул уурхайн төсөл /Завхан аймаг /2012-2016/.....	33
21. Хүснэгт 21. Хуралдааны ирц /Орхон аймаг/.....	34
22. Хүснэгт 22. Уул уурхайн төсөл /Орхон аймаг /2012-2016/.....	34
23. Хүснэгт 23. Хуралдааны ирц /Өвөрхангай аймаг/.....	36
24. Хүснэгт 24. Уул уурхайн төсөл /Өвөрхангай аймаг 2012-2016/.....	37
25. Хүснэгт 25. Хуралдааны ирц /Өмнөговь аймаг/.....	38
26. Хүснэгт 26. Уул уурхайн төсөл /Өмнөговь аймаг 2012-2016/.....	39
27. Хүснэгт 27. Хуралдааны ирц /Сүхбаатар аймаг/.....	41
28. Хүснэгт 28. Уул уурхайн төсөл /Сүхбаатар аймаг 2012-2016/.....	42
29. Хүснэгт 29. Хуралдааны ирц /Сэлэнгэ аймаг/ /2012-2016/.....	44
30. Хүснэгт 30. Уул уурхайн төсөл /Сэлэнгэ аймаг 2012-2016/.....	45
31. Хүснэгт. 31. Хуралдааны ирц /Төв аймаг /.....	46
32. Хүснэгт 32. Уул уурхайн төсөл /Төв аймаг /2012-2016/.....	48
33. Хүснэгт 33. Хуралдааны ирц /Увс аймаг /.....	52
34. Хүснэгт 34. Уул уурхайн төсөл /Увс аймаг 2012-2016/.....	53
35. Хүснэгт 35. Хуралдааны ирц /Улаанбаатар хот/.....	54
36. Хүснэгт 36. Уул уурхайн төсөл /Улаанбаатар хот 2012-2016/.....	55
37. Хүснэгт 37. Хуралдааны ирц /Ховд аймаг/.....	58
38. Хүснэгт 38. Уул уурхайн төсөл /Ховд аймаг /2012-2016/.....	59
39. Хүснэгт 39. Хуралдааны ирц /Хөвсгөл аймаг /2012-2016/.....	59
40. Хүснэгт 40. Уул уурхайн төсөл /Хөвсгөл аймаг /2012-2016/.....	60
41. Хүснэгт 41. Хуралдааны ирц /Хэнтий аймаг /2012-2016/.....	61
42. Хүснэгт 42. Уул уурхайн төсөл /Хэнтий аймаг 2012-2016/.....	63
43. Хүснэгт 43. Багийн Нийтийн Хурлын Ирцийн бүртгэлийн загвар.....	70

НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Байгаль орчны салбарт 2009-2012 онд хийгдсэн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд салбарын үндсэн харилцааг зохицуулж байсан 33 хуулиас 18 хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган, бодлогын хувьд шинэ агуулга, зохицуулалтаар шинэчилсэн. Уг эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг шинэчилсэн найруулгаар УИХ-аас баталсан. Шинэчлэгдэн батлагдсан хуулийг хэрэгжүүлсэн өнгөрсөн 4 жилийн хугацаанд хуулийн зарим зүйл заалт хоорондоо зөрчилдөх, зохицуулалтын хувьд давхцах, тодорхой бус хоёрдмол утга илэрхийлэх, төсөл хэрэгжүүлэгчид эдийн засгийн болоод цаг хугацааны хүндрэл учруулах зэрэг хүндрэл бэрхшээл гарч байгаа тул эдгээр асуудлыг эрх зүйн зохицуулалтын хувьд сайжруулан зохицуулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

1.1. Судалгааны зорилго

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Багийн Нийтийн хурлаар хэлэлцүүлэх нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хэрэгжилтийг сайжруулах болон байгалийн нөөц ашиглан хэрэгжүүлж буй төслөөс байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах замаар орчны бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлэх, оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох зарчмуудыг хэрэгжүүлэх зохистой арга зам мөн эсэхэд үнэлгээ хийж дүгнэлт гарган, эрхзүйн орчныг сайжруулах зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

1.2. Судалгааны хамрах хүрээ

Судалгааг 2012 оноос 2016 онуудын хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж батлагдсан уул уурхайн төслүүдэд авагдсан төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэлийн өнөөгийн байдлыг холбогдох эх үүсвэрээс түүвэрлэн, үнэлгээ хийж дүгнэлт гарган, эрхзүйн орчныг сайжруулах зөвлөмж боловсруулна.

1.3. Судалгааны арга зүй

Зөвлөх нь баримт бичгийн, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах аргуудыг хэрэглэн хараат бус, бие даасан, баримтат үндэслэх зарчмыг баримтлан судалгааг хийв.

Хоёр. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг 2012-2016 оны хооронд багийн нийтийн хурлаар хэлэлцүүлсэн байдал

Байгалийн нөөцийг ашиглагч нь хамгаалагч байх зарчим хэрэгжих, Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилсан байгалийн нөөцийн ашиглалт-хамгаалалтын зөв механизмыг бүрдүүлэх, олон нийтийн оролцоог хангах, орон нутгийн иргэдийг оролцуулж, тэдний санал хүсэлтийг авч байх асуудлыг хуульчилсан нь зарчмын шинжтэй томоохон дэвшил болсон.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтад нарийвчилсан үнэлгээний тайланд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл гэж заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд заавал авагдах бүрдүүлбэр болсон байна.

Хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, зарим асуудлыг нарийвчлан зохицуулах зорилгоор Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн “Аргачлал батлах тухай” А-117 дугаар тушаалаар “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал” болон “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал” тус тус батлагджээ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш буюу 2012 оноос 2016 оны сүүлийн байдлаар Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний Мэргэжлийн зөвлөлөөр нийт 2087 байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан тайлан хэлэлцэж батлагдсанаас ашигт малтмал олборлох 297 төслийн тайлан батлагдсан байна /график 1/. 2012 оноос 2015 оны хооронд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж батлагдсан уул уурхайн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан тайлан харьцангуй тогтмол хэмжээнд буюу 60-74 хооронд хэлбэлзэж байсан байна.

Харин 2016 онд уул уурхайн 38 тайлан хэлэлцэж батлагдсан нь Улсын Их Хурлын ээлжид сонгууль, засгийн газрын шинэ бүрэлдэхүүн түүнийг дагасан яамны бүтэц шинэчлэгдсэн зэргээс дам хамааралтай гэж үзэж болохоор байна.


График 1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан тайлангийн тоо 2012-2016



Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгохыг хориглох тухай хуулийн үйлчлэл мөн хөрөнгө оруулалтын хэмжээтэй шууд хамааралтайгаар нийт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоо 2008 оноос хойш тогтмол буурч байсан байна.

Улсын Их Хурлаас Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгохыг хориглосон хуулийн үйлчлэх хугацаа 2015 оны 01 дүгээр сараас дуусаж, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгож эхэлснээр 2016 оны жилийн эцсийн байдлаар тусгай зөвшөөрлийн тоо 2012 оны түвшинд хүрсэн байна /график 2/.


График 2. Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, жилийн эцсийн байдлаар, 2008-2016



Эх сурвалж: АМГТГ газар 2017 он

Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий 84 аж ахуйн нэгж /хавсралт 5.3/ дээрх уул уурхайн төслийн нарийвчилсан үнэлгээг боловсруулсан байх ба нэр бүхий 25 аж ахуйн нэгж /график 3/ нийт үнэлгээний 66.8 хувийг дангаараа боловсруулсан байна. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий дээрх аж ахуйн нэгжүүдийн уул уурхайн төслийн нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулсан байдалд учир дутагдалтай зүйлс байгааг мөн төсөл хэрэгжих газрын захиргааны санал, багийн нийтийн хурлын тэмдэглэл үйлдсэн байдалд зайлшгүй анхаарах шаардлагатай асуудлуудыг энэхүү судалгааны тайлангийн дүгнэлт, зөвлөмж хэсэгт тэмдэглэгдсэн болно.

График 3. Нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж




Эх сурвалж: БОАЖЯам 2017 он

2.1. Архангай аймаг

Архангай аймгийн нутаг дэвсгэрийн 0,1 хувийг буюу 78,7 мян.га талбай бүхий ашигт малтмалын ашиглалтын 26, хайгуулын 15, нийт 41 тусгай зөвшөөрөл 2016 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр бүртгэлтэй байна¹. Тус аймгийн нутаг дэвсгэрт Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2012-2016 оны хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох нэгжээр хэлэлцүүлж, батлагдсан алтны орд ашиглах 5 төсөл (хүснэгт 2) байх бөгөөд бүх төслүүд Цэнхэр сум (Зураг 1)-нд хэрэгжиж байна.

Зураг 1. Архангай аймаг



Хүснэгт 1. Хуралдааны ирц /Архангай аймаг/

№	ҮСХорооны 2015 оны тайланд туссан нийт өрхийн дундаж тоо	БИНХурлын ирцийн дундаж тоо /хуралдааны тэмдэглэлд тусгагдсанаар/	Хуралдаан хүчин төгөлдөр болох хуулиар тогтоосон шалгуур үзүүлэлт
1	269	65	67

Иргэдийн нийтийн хуралд оролцогчдоос гаргасан саналууд:

1. Орон нутгаас тодорхой тооны ажилтан авч ажиллуулах
2. Соёлын өвийг хамгаалах
3. Худаг ус нэмж гаргах
4. Бэлэн мөнгө тараахаас илүүтэй малжуулах ажил зохион байгуулах
5. Шинэ техник технологи нэвтрүүлэх
6. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад санаачилгатай ажиллах
7. Шинэ техник технологи нэвтрүүлэх
8. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад санаачилгатай ажиллах
9. Зам засуулах
10. Оюутны төлбөр дээр дэмжлэг үзүүлэх, сурагчийн форм авч өгөх
11. Орон нутагт хэрэгтэй бүтээн байгуулалт хийх

¹ Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны жилийн эцсийн тайлан мэдээ, www.mram.gov.mn

Хүснэгт 2. Уул уурхайн төсөл 2012-2016 он

Төслийн огноо	Төслийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж	Төсөл хэрэгжих аймаг, сум	Ашигт малтмалын төрөл
2015	Өлийн голын алтны шороон ордыг ашиглах явцад эвдэрсэн газарт эфель угааж нөхөн сэргээлт хийх	Монгол газар ХХК	Архангай аймгийн Цэнхэр сум	Алт
2015	Харгуйтын алтны шороон ордыг ашиглах явцад эвдэрсэн газарт эфель угааж нөхөн сэргээлт хийх	Монгол газар ХХК	Архангай аймгийн Цэнхэр сум	Алт
2016	Харгуйтын амны баруун салаа алтны шороон орд	Алтай голд ХХК	Архангай аймгийн Цэнхэр сум	Алт
2016	Өлзийт тээлийн алтны шороон орд	БМНС ХХК	Архангай аймгийн Цэнхэр сум	Алт
2016	Өлийн гол алтны шороон ордыг ашиглах	Батбродерс ХХК	Архангай аймгийн Цэнхэр сум	Алт

2.2. Баян-Өлгий аймаг

Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрийн 0,2 хувийг буюу 337,3 мян.га талбай бүхий ашигт малтмалын ашиглалтын 25, хайгуулын 63, нийт 88 тусгай зөвшөөрөл 2016 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр бүртгэлтэй байна². Тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулах холимог металлын 1, вольфрамын 2 нийт 3 төсөл (хүснэгт 4)-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2012-2016 оны хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох нэгжээр хэлэлцэгдэн батлагдсан байх ба бүгд Ногоон нуур сум (зураг 2)-нд хэрэгжиж байна.

Зураг 2. Баян-Өлгий аймаг



Хүснэгт 3. Хуралдааны ирц /Баян-Өлгий аймаг/

№	ҮСХорооны 2015 оны тайланд туссан нийт өрхийн дундаж тоо	БИНХурлын ирцийн дундаж тоо /хуралдааны тэмдэглэлд тусгагдсанаар/	Хуралдаан хүчин төгөлдөр болох хуулиар тогтоосон шалгуур үзүүлэлт
1	210	56.5	52

Иргэдийн нийтийн хуралд оролцогчдоос гаргасан саналууд:

1. Олон хүний хаваржаа өвөлжөө байгаа мал амьтан хонхорт ороод үхдэг, бордоо, элдэв бодис идээд мал үхдэг асуудалд анхаарч ажиллах

² Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны жилийн эцсийн тайлан мэдээ, www.mram.gov.mn

2. Олборлолт явуулах газар өвөлжөө, хаваржаа байрладаг уурхайн үйл ажиллагаа явуулахаас татгалзаж байна
3. Багийн ИНХ, БЗД-тай нягт хамтарч ажиллах
4. Уурхайг хурдан хугацаанд ажиллуулах хүсэлтэй
5. Багийн иргэдийн аж амьдрал энэ уурхайтай шууд хамаатай тул ашиглалтад хурдан ороосой гэж хүсэж байна
6. Багт 10 кв шугамаар цахилгаан өгөх
7. Уурхайн ашиглалтад орвол хурдан ажилламаар байна
8. Сүмийн гадна талаар хашаа барьж өгөх
9. Тариа тарихад машин, техникээр тусламж үзүүлэх


Хүснэгт 4. Уул уурхайн төсөл 2012-2016

Төслийн огноо	Төслийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж	Төсөл хэрэгжих аймаг, сум	Ашигт малтмалын төрөл
2014	Дулаан хар уул холимог металлын ордыг ашиглах	Юүшэнгминг ХХК	Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сум	Холимог металл
2015	Улаан уулын вольфрам-ын орд	Лужё орд ХХК	Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сум	Вольфрам
2015	Цүнхэгийн вольфрам-ын орд	Лужё орд ХХК	Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сум	Вольфрам

2.3. Баянхонгор аймаг

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийн 0,3 хувийг буюу 546,8 мян.га талбай бүхий ашигт малтмалын ашиглалтын 82, хайгуулын 100, нийт 182 тусгай зөвшөөрөл 2016 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр бүртгэлтэй байна³. Тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулах алтны 8, нүүрсний 2, зэс молибдений 1 нийт 11 төсөл (хүснэгт 6)-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2012-2016 оны хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох нэгжээр хэлэлцэгдэн батлагдаж Баянговь, Баян овоо, Галуут, Бөмбөгөр, Шинэжинст сумд (зураг 3)-ын нутагт хэрэгжсэн байна.

Зураг 3. Баянхонгор аймаг



Хүснэгт 5. Хуралдааны ирц /Баянхонгор аймаг/

№	ҮСХорооны 2015 оны тайланд туссан нийт өрхийн дундаж тоо	БИНХурлын ирцийн дундаж тоо /хуралдааны тэмдэглэлд тусгагдсанаар/	Хуралдаан хүчин төгөлдөр болох хуулиар тогтоосон шалгуур үзүүлэлт
1	190	62	47

Иргэдийн нийтийн хуралд оролцогчдоос гаргасан саналууд:

1. Бэлчээр сүйтгэхгүй байх
2. Нутгийн иргэдийн санал бодлыг авч байх

³ Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны жилийн эцсийн тайлан мэдээ, www.mram.gov.mn

3. Мөнгөн ус болон бусад хортой бодис хэрэглэхгүй байх
4. Малчдын усны нөөцөд нөлөөлөхгүй байх
5. Орон нутгийн иргэдээс ажилд авах
6. Шинэ техник технологи нэвтрүүлэх
7. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад санаачилгатай ажиллах
8. Орон нутгаас ажилтан авах
9. Мал багатай иргэдийг малжуулах
10. Багаас их дээд сургуульд амжилттай суралцаж байгаа оюутнуудын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх


Хүснэгт 6. Уул уурхайн төсөл 2012-2016 он

Төслийн огноо	Төслийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж	Төсөл хэрэгжих аймаг, сум	Ашигт малтмалын төрөл
2012	Зуун модны молибден-зэсийн орд	Аниан ресорсиз ХХК	Баянхонгор аймгийн Шинэжинст сум	Зэс
2012	Хотгорын нүүрсний орд ашиглах	Гоби коул энд Энержи ХХК	Баянхонгор аймгийн Шинэжинст сум	Нүүрс
2012	Цахир толгойн зэс алтны ордыг ашиглах	Юниверсал коппер ХХК	Баянхонгор аймгийн Баянговь сум	Алт
2013	Цагаан цахир уулын алтны үндсэн орд	Спейшл майнинз ХХК	Баянхонгор аймгийн Баян Овоо сум	Алт
2013	Манж худгийн алтны шороон орд	Нинж мөрөн ХХК	Баянхонгор аймгийн Галуут сум	Алт
2013	Тогоотын амны алтны шороон орд	Ай Эн Ди ХХК	Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум	Алт
2014	Хөх толгойн нүүрсний орд	Хуа Бэй Куане ХХК	Баянхонгор аймгийн Шинэжинст сум	Нүүрс
2014	Гучингийн сайр алтны шороон орд	Андын тэмүүлэл	Баянхонгор аймгийн Баян Овоо сум	Алт
2014	Хоолой худаг алтны шороон орд	Тинаха ХХК	Баянхонгор аймаг Галуут сум	Алт
2015	Хатавчийн хөндийн алтны үндсэн орд	Эрдэнэминас ХХК	Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум	Алт
2015	Алтны хүдэр баяжуулах	Хонгорын хүдэр ХХК	Баянхонгор аймгийн Баян-Овоо сум	Алт

2.4. Булган аймаг

Булган аймгийн нутаг дэвсгэрийн 0,4 хувийг буюу 598,6 мян.га талбай бүхий ашигт малтмалын ашиглалтын 65, хайгуулын 69, нийт 134 тусгай зөвшөөрөл 2016 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр бүртгэлтэй байна⁴. Тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулах алтны 7, барилгын 2, төмрийн 1 нийт 10 төсөл (хүснэгт 8)-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2012-2016 оны хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох нэгжээр батлагдаж Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Дашинчилэн сумд (зураг 4)-ын нутагт хэрэгжсэн байна.

Зураг 4. Булган аймаг



Хүснэгт 7. Хуралдааны ирц /Булган аймаг/

№	ҮСХорооны 2015 оны тайланд туссан нийт өрхийн дундаж тоо	БИНХурлын ирцийн дундаж тоо /хуралдааны тэмдэглэлд тусгагдсанаар/	Хуралдаан хүчин төгөлдөр болох хуулиар тогтоосон шалгуур үзүүлэлт
1	212	50.2	53

Монгол улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10-т заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан авч үзвэл иргэдийн нийтийн хуралд 53 иргэн хүрэлцэн тохиолдолд хурал хүчин төгөлдөр болохоор байна.

Иргэдийн нийтийн хуралд оролцогчдоос гаргасан саналууд:

⁴ Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны жилийн эцсийн тайлан мэдээ, www.mram.gov.mn

1. Сумын төвд худалдааны зах барих
2. Мод үржүүлгийн газар байгуулах
3. Хөдөөгийн малчдад хүргэх соёлын үйлчилгээг дэмжих
4. Хүлэмжийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
5. Спортын талбайтай болгох
6. Гүний худаг гаргах
7. Орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх
8. Төслийг хэрэгжүүлэхэд татгалзах зүйлгүй
9. Орон нутгаас ажилтан авах
10. Мах, сүү, цагаан идээ авч байх
11. Орон нутгаас ажилтан авах
12. Сум орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх
13. Тоосжилтыг багасгах тал дээр анхаарч ажиллах
14. Нөхөн сэргээлтийн ажилд орон нутгийн иргэдийг оролцуулах
15. Нэг замаар тээвэрлэлт явуулах


Хүснэгт 8. Уул уурхайн төсөл 2012-2016 он

Төслийн огноо	Төслийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж	Төсөл хэрэгжих аймаг, сум	Ашигт малтмал
2012	Галт уулын шаарганы орд ашиглах	Ариунхайрхан ХХК	Булган аймгийн Хишиг-Өндөр сум	Барилгын чулуу
2012	Алтны шороон ордыг ашиглах	Хүслэмж ХХК	Булган аймгийн Бүрэг хангай сум	Алт
2012	Алтны шороон орд ашиглах	Бэрхийн нурамт ХХК	Булган аймгийн Дашинчилэн сум	Алт
2013	Өгөөмөр алтны шороон ордыг ашиглах	Хос хас ХХК	Булган аймгийн Бүрэгхангай сум	Алт
2013	Өгөөмөр алтны шороон ордыг ашиглах	Хос хас ХХК	Булган аймгийн Бүрэгхангай сум	Алт
2014	Хүрэн булаг орд	Хүрэнбулаг ХХК	Булган аймгийн Бүрэгхангай сум	Барилгын чулуу
2015	Доргонтын алтны шороон орд ашиглах	Алтандорнод Монгол ХХК	Булган аймгийн Дашинчилэн сум	Алт
2015	Цоохор морьт алтны шороон орд ашиглах	Өгөөж баян хангай ХХК	Булган аймгийн Бүрэгхангай сум	Алт
2015	Туулын зүүн дэнжийн алтны шороон орд	Хамтын эх булаг ХХК	Булган аймгийн Бүрэгхангай сум	Алт
2015	Өлзийт овоо төмрийн хүдрийн ордыг ашиглах	Нүүдэлчин айрон ресурс ХХК	Булган аймгийн Бүрэгхангай сум	Төмөр

2.5. Говь-Алтай аймаг

Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрийн 0,8 хувийг буюу 1326,1 мян.га талбай бүхий ашигт малтмалын ашиглалтын 43, хайгуулын 149, нийт 192 тусгай зөвшөөрөл 2016 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр бүртгэлтэй байна⁵. Тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулах алтны 1, нүүрсний 2, төмрийн 2 нийт 5 төсөл (хүснэгт 10)-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2012-2016 оны хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох нэгжээр батлагдаж Бигэр, Тайшир, Цээл, Чандмань, Дэлгэр сумд (зураг 5)-ын нутагт хэрэгжсэн байна.

Зураг 5. Говь-Алтай аймаг



Хүснэгт 9. Хуралдааны ирц / Говь-Алтай аймаг/

№	ҮСХорооны 2015 оны тайланд туссан нийт өрхийн дундаж тоо	БИНХурлын ирцийн дундаж тоо /хуралдааны тэмдэглэлд тусгагдсанаар/	Хуралдаан хүчин төгөлдөр болох хуулиар тогтоосон шалгуур үзүүлэлт
1	150	27.5	37

Иргэдийн нийтийн хуралд оролцогчдоос гаргасан саналууд:

1. Хүдэр зөөх замаа засаж янзалсны дараа тээвэрлэлт эхлүүлэх
2. Уурхайн бүсэд хамаарах малчдын өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны нөхөн төлбөрийг барагдуулах
3. Ажилчдын байраа сумын төвд байрлуулах

⁵ Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны жилийн эцсийн тайлан мэдээ, www.mram.gov.mn

4. Орон нутгаас ажилтан авах
5. Орон нутгийн ядуу, хөгжлийн бэрхиээлтэй, оюутан залууст дэмжлэг үзүүлэх
6. Уурхай тойруулж хамгаалалтын тор татах
7. Нутгийн иргэдэд нүүрсний үнэ хөнгөлж өгөх
8. Уурхайн ойр орчмын зам дагуух нүүрсний хаягдал хогийг цэвэрлэх


Хүснэгт 10. Уул уурхайн төсөл 2012-2016 он

2. Төслийн огноо	3. Төслийн нэр	4. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж	6. Төсөл хэрэгжих аймаг, сум	7. Ашигт малтмалын төрөл
2012	Алтны шороон ордоос ил аргаар олборлох	Марко Поло ХХК	Говь-Алтай аймгийн Бигэр сум	Алт
2012	Бор нурууны төмрийн хүдрийн ордыг ашиглах	Тайширын хүдэр ХХК	Говь-Алтай Тайшир сум	Төмөр
2013	Таяннуурын төмрийн хүдрийн орд ашиглах	Алтайн хүдэр ХХК	Говь- Алтай аймгийн Цээл сум	Төмөр
2014	Зээгтийн нүүрсний ордын MV-017438 А тоот тусгай зөвшөөрөлтэй Асгатын талбайг ашиглах	Гоби коул энерги ХХК	Говь-Алтай аймгийн Чандмань сум	Нүүрс
2014	Хөв булаг нэртэй газар хүрэн нүүрсний орд ашиглах	Мандал Алтай групп ХХК	Говь-Алтай Дэлгэр сум	Нүүрс

2.6. Дархан-Уул аймаг

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрийн 0,02 хувийг буюу 26,2 мян.га талбай бүхий ашигт малтмалын ашиглалтын 68, хайгуулын 23, нийт 91 тусгай зөвшөөрөл 2016 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр бүртгэлтэй байна⁶. Тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулах алтны 2, нүүрсний 1, шохойн чулууны 3, элсний 1 нийт 7 төсөл (хүснэгт 12)-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2012-2016 оны хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох нэгжээр батлагдаж Хонгор, Шарын гол, Орхон сумд (зураг 6)-ын нутагт хэрэгжсэн байна.

Зураг 6. Дархан-Уул аймаг



Хүснэгт 11. Хуралдааны ирц / Говь-Алтай аймаг/

№	ҮСХорооны 2015 оны тайланд туссан нийт өрхийн дундаж тоо	БИНХурлын ирцийн дундаж тоо /хуралдааны тэмдэглэлд тусгагдсанаар/	Хуралдаан хүчин төгөлдөр болох хуулиар тогтоосон шалгуур үзүүлэлт
1	594	57	148

Иргэдийн нийтийн хуралд оролцогчдоос гаргасан саналууд:

1. Орон нутгаас ажилтан авах
2. Тоосжилтыг бага байлгах арга хэмжээ авах
3. Үйлдвэрлэсэн блоккийг сумын иргэдэд хөнгөлөлттэй үнээр өгөх
4. Уул уурхайд хэрэглэсэн усаа голд нийлүүлэхгүй байх
5. Орчны бохирдол, тоосжилтыг багасгах

⁶ Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны жилийн эцсийн тайлан мэдээ, www.mram.gov.mn

6. Уул уурхайн автомашиныуд батлагдсан замаар явах
7. Цианид натри хэрэглэхгүй байх
8. Багийн төвийг тохижуулах
9. Олон наст ургамал тарих
10. Нөхөн сэргээлт хийхдээ жижиг хэмжээтэй нуур үлдээх


Хүснэгт 12. Уул уурхайн төсөл 2012-2016 он

Төслийн огноо	Төслийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж	Төсөл хэрэгжих аймаг, сум	Ашигт малтмалын төрөл
2012	Шаазгайтын ил уурхай	Шарын гол ХК	Дархан-Уул аймгийн Шарын гол сум	Нүүрс
2012	Шийрийн хөндийн шохойн чулууны орд ашиглах	Мөнхболор Эрдэнэ ХХК	Дархан-Уул аймаг Хонгор сум	Шохойн чулуу
2013	Цохио толгой -2 шохойн орд	Идэрхайрхан ХХК	Дархан-Уул аймаг Хонгор сум	Шохойн чулуу
2014	МУ-017362 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий их булангийн элс хайрганы ордыг ил аргаар ашиглах	Сонсголон хайрхан ХХК	Дархан уул аймгийн Дархан, Орхон сум	Элс
2015	Цогтын шохойн чулууны 5-р орд	Силикат ХХК	Дархан-Уул аймгийн Хонгор сум	Шохойн чулуу
2015	Зоолуухарын алтны шороон орд	Очир ундраа ХХК	Дархан уул аймгийн Хонгор сум	Алт
2015	Хавчуугийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах	Багатаян ХХК	Дархан уул аймгийн Шарын гол сум	Алт

2.7. Дорноговь аймаг

Дорноговь аймгийн нутаг дэвсгэрийн 1,4 хувийг буюу 2146,6 мян.га талбай бүхий ашигт малтмалын ашиглалтын 163, хайгуулын 294, нийт 457 тусгай зөвшөөрөл 2016 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр бүртгэлтэй байна⁷. Тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулах жоншны 15, нүүрсний 6, шохойн чулууны 3, төмрийн 2, гөлтгөнийн 2, антрацтын 1, цеолитийн 1, зэсийн 1, ураны 1, газрын тосны 1 нийт 33 төсөл (хүснэгт 14)-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2012-2016 оны хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох нэгжээр батлагдаж Сайхандулаан, Айраг, Алтанширээ, Мандах, Өргөн, Иххэт, Улаанбадрах, Эрдэнэ, Хатанбулаг, Даланжаргалан сумд (зураг 7)-ын нутагт хэрэгжсэн байна.

Зураг 7. Дорноговь аймаг



Хүснэгт 13. Хуралдааны ирц /Дорноговь аймаг/

№	ҮСХорооны 2015 оны тайланд туссан нийт өрхийн дундаж тоо	БИНХурлын ирцийн дундаж тоо /хуралдааны тэмдэглэлд тусгагдсанаар/	Хуралдаан хүчин төгөлдөр болох хуулиар тогтоосон шалгуур үзүүлэлт
1	158	44	40

Иргэдийн нийтийн хуралд оролцогчдоос гаргасан саналууд:

1. Орон нутгаас ажилтан авах
2. Нөхөн сэргээлтийг сайн хийх
3. Уул уурхайн үйл ажиллагаа явуулахгүй байх

⁷ Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны жилийн эцсийн тайлан мэдээ, www.mram.gov.mn

4. Уул уурхайтай ойр гүний худгуудад тогтмол шинжилгээ хийх
5. Сум орон нутгийн хөгжилд хувь нэмрээ ихээр оруулах
6. Уул уурхайд хэрэглэсэн усаа голд нийлүүлэхгүй байх
7. Соёлын өвийн дурсгалт зүйлсийг хамгаалах
8. Орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх
9. Байгаль орчны мэргэжилтэн орон нутгаас бэлдэх
10. Хийж хэрэгжүүлсэн ажлаа тогтмол тайлагнадаг байх
11. Нэг л замаар тээвэрлэлтээ хийх, засаж сэлбэх
12. Сүү цагаан идээ худалдаж авч байх
13. Гүний худаг гаргуулах
14. Уурхайг ажиллуулахгүй байх
15. Нөхөн сэргээлт сайн чанартай хийх
16. Багийн төвийн урсгал засварт дэмжлэг үзүүлэх
17. Усны дээжид хагас жилдээ шинжилгээ хийж байх
18. Шүүрлийн усыг нөөцөлж цөөрөм байгуулах Сайжруулсан зам тавих
19. Тээвэрлэлт хийж байгаа автомашинд таних тэмдэгтэй байх
20. Зам дагуу тэмдэг тэмдэглэгээ хийх
21. Уурхайн шавхан зайлуулсан усаар цөөрөм үүсгэх
22. Гүний худаг гаргаж өгөх Уурхайгаас гарах шүүрлийн усаа хэрхэн зохицуулах
23. Орон нутгаас тодорхой тооны ажилтан авч ажиллуулах
24. Уурхайгаас гарах шүүрлийн усаа хэрхэн зохицуулах
25. Баталсан замын чиглэлээр тээвэрлэлт хийх, олон салаа зам гаргахгүй байх
26. Орон нутгаас ажилтан авдаг боловч удалгүй халдаг, НД төлдөггүй байдалд онцгой анхаарах
27. Зам дагуу их хог хаяж байна
28. Рашааны эхийг хамгаалах
29. Гүний худаг гаргуулах
30. Багийн төвийг тохижуулах
31. Замын асуудалд онцгой анхаарах
32. Орон нутгийн иргэдэд нүүрс өгөх
33. Орон нутгаас ажилтан авах
34. Хоршооллыг дэмжиж ажиллах Сайжруулсан зам тавих
35. Золбин нохой тэжээхгүй байх
36. Зориулалтын хашаа барих
37. Орон нутгаас ажилчин авах
38. Хог хаягдлаа цэгцтэй байлгах
39. Уурхайн ойр орчмын худгийн усанд хэмжилт хийж тоолох
40. Гүний худаг гаргаж өгөх
41. Замын нөхцөлийг сайжруулж тээвэрлэлт явуулах
42. Орон нутгийн иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулж ажилд авах
43. Нарангийн хоолойгоос үйлдвэрийн зориулалтаар авах усны хэрэглээнд иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх
44. Нуурыг нөхөн сэргээх
45. Хамгаалалтын хашаа, хайс барих
46. Нүүрсийг хөнгөлөлттэй үнээр өгөх
47. Нөхөн сэргээлт чанартай хийх

Хүснэгт 14. Уул уурхайн төсөл 2012-2016 он

Төслийн огноо	Төслийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж	Төсөл хэрэгжих аймаг, сум	Ашигт малтмалын төрөл
2012	Борхулангийн нүүрсний орд ашиглах	Мига эрин ХХК	Дорноговь аймгийн Сайхандулаан сум	Нүүрс


2012	Хайлуур жоншны орд ашиглах	Хэрлэн импекс ХХК	Дорноговь аймгийн Айраг сум	Жонш
2012	Жоншт толгой хайлуур жоншны орд	Талст бурхан ХХК	Дорноговь аймаг Айраг сум	Жонш
2012	Эрдэнэцогтын хүрэн нүүрсний орд	Синотүм Монголиа ХХК	Дорноговь аймгийн Алтанширээ сум	Нүүрс
2012	Мандах нуурын антрацитын орд	Их говь энерги ХХК	Дорноговь аймгийн Мандах сум	Антрацит
2012	Бор толгойн хайлуур жоншны ордыг ашиглах	Жеми интернейшнл ХХК	Дорноговь аймгийн Өргөн сум	Жонш
2012	Хамар усны жоншны орд	Баян тэгш импекс	Дорноговь аймгийн Иххэт сум	Жонш
2013	Цагаан цавын цеолитын орд ашиглах	Монцео ХХК	Дорноговь аймгийн Улаанбадрах сум	Цеолит
2013	Оюут улааны зэс ордыг ашиглах	Вантаже ХХК	Дорноговь аймгийн Сайхандулаан сум	Зэс
2013	Хөх дэл -1 хайлуур жоншны орд ашиглах	Хөх төр ХХК	Дорноговь аймгийн Айраг сум	Жонш
2013	Галшарын хүрэн нүүрсний орд	Занаду энерги ресорс монголиа ХХК	Дорноговь аймгийн Иххэт сум,Хэнтий аймгийн Галшар сум	Нүүрс
2013	Шохойн чулууны орд ашиглах	Ус орчин ХХК	Дорноговь аймгийн Өргөн сум	Шохойн чулуу
2014	Сулинхээр-ХХШ талбайн газрын тос	Шунхлай энерги ХХК	Дорноговь аймгийн Эрдэнэ	Газрын тос
2013	Цагаан суваргын молибден –зэс порфирын орд	Монголын алт /МАК/ ХХК	Дорноговь аймгийн Мандах сум	Зэс
2014	Бор хулангийн нүүрсний орд	Мига эрин ХХК	Дорноговь аймгийн Сайхандулаан сум	Нүүрс
2014	Сэрүүн цагааны хайлуур жоншны орд	Тэнүүн байгаль ХХК	Дорноговь аймгийн Даланжаргалан сум	Жонш
2014	Хүрэн-1 хайлуур жоншны орд ашиглах	Айваору ХХК	Дорноговь аймгийн Айраг сум	Жонш
2014	Жоншт толгой хайлуур жоншны орд	Экилешия ХХК	Дорноговь аймгийн Айраг сум	Жонш
2014	Алагтоогоогийн нүүрс	Пауэрлэнд ХХК	Дорноговь аймгийн Даланжаргалан сум	Нүүрс
2014	Хөх цав шохойн чулууны ордыг ашиглах	Монголын алт /МАК/ ХХК	Дорноговь Даланжаргалан сум	Шохойн чулуу
2014	Доод дөрвөлжингийн төмрийн хүдрийн орд	Жү Тай Юуан ХХК	Дорноговь аймгийн Даланжаргалан сум	Төмөр
2014	Баруун цагаан дэлийн 175-р илрэл	Дунфанлунма ХХК	Дорноговь аймаг Айраг сум	Жонш
2014	Цагаан дэл нэртэй хайлуур жоншны орд	Мөнхболор хүрээ ХХК	Дорноговь аймгийн Айраг сум	Жонш
2015	Сайхан гашууны хайлуур жоншны орд	Да Сайн уул ХХК	Дорноговь аймгийн Даланжаргалан сум	Жонш
2015	Өргөний хайлуур жоншны ордыг ашиглах	Ремар ХХК	Дорноговь аймгийн Өргөн сум	Жонш
2015	Хөтөл улаан хайлуур жоншны орд ашиглах	Дүншинхэние	Дорноговь аймгийн Даланжаргалан сум	Жонш

2015	Үнэгтийн гөлтгөнийн уурхай	Эрэл ХХК	Дорноговь аймгийн Улаанбадрах сум	Гөлтгөн
2015	Билүүтийн шохойн чулууны орд	Эрэл ХХК	Дорноговь аймгийн Даланжаргалан сум	Шохойн чулуу
2015	Элстэйн төмрийн хүдрийн орд	Мон лаа ХХК	Дорноговь аймгийн Хатанбулаг сум	Төмөр
2015	Зөөвч овоо ураны орд	Кожеговь ХХК	Дорноговь аймгийн Улаанбадрах сум	Уран
2016	Үнэгтийн гөлтгөнийн уурхай	Арвин хад ХХК	Дорноговь аймгийн Сайхандулаан сум	Гөлтгөн
2016	Далангийн чулуун нүүрсний орд	Штайнколе ХХК	Дорноговь аймгийн Даланжаргалан сум	Нүүрс
2016	Цагаан элгэн 1 хайлуур жоншны ордыг олборлох	Болоргол ХХК	Дорноговь аймгийн Иххэт сум	Жонш

2.8. Дорнод аймаг

Дорнод аймгийн нутаг дэвсгэрийн 0,4 хувийг буюу 684,4 мян.га талбай бүхий ашигт малтмалын ашиглалтын 67, хайгуулын 131, нийт 198 тусгай зөвшөөрөл 2016 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр бүртгэлтэй байна⁸. Тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулах алтны 6, газрын тосны 3, төмрийн 3, нүүрсний 2, жоншны 2, холимог металлын 1, элсний 1, нийт 18 төсөл (хүснэгт 16)-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2012-2016 оны хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох нэгжээр батлагдаж Баяндун, Булган, Хэрлэн, Матад, Халх гол, Дашбалбар сумд (зураг 8)-ын нутагт хэрэгжсэн байна.

Зураг 8. Дорнод аймаг



Хүснэгт 15. Хуралдааны ирц / Дорнод аймаг/

№	ҮСХорооны 2015 оны тайланд туссан нийт өрхийн дундаж тоо	БИНХурлын ирцийн дундаж тоо /хуралдааны тэмдэглэлд тусгагдсанаар/	Хуралдаан хүчин төгөлдөр болох хуулиар тогтоосон шалгуур үзүүлэлт
1	477	65	119

Иргэдийн нийтийн хуралд оролцогчдоос гаргасан саналууд:

1. Гүний худаг гаргаж өгөх
2. Мах сүү цагаан идээ худалдаж авах
3. Шинээр зам гаргахгүй байх
4. Орон нутгаас ажилтан авах
5. Орон нутгаас тодорхой тооны ажилтан авч ажиллуулах
6. Нөхөн сэргээлтийг сайн хийх
7. Мах сүү, сүүн бүтээгдэхүүн худалдаж авах
8. Гүний худаг гаргуулах
9. Хайгуулын шатанд санал аваагүй байж төрийн холбогдох байгууллагаас шийдвэр нь гарсны дараа малчдаас санал авах гэж байгаа нь илүүц ажил байна
10. Орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх
11. Оюутны сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх

⁸ Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны жилийн эцсийн тайлан мэдээ, www.mram.gov.mn

12. Оюутны төлбөрт дэмжлэг үзүүлэх

13. Тээвэрлэлтийн үед үүсэж байгаа тоосжилтыг бууруулах тал дээр анхаарч ажиллах

Хүснэгт 16. Уул уурхайн төсөл 2012-2016 он


Төслийн огноо	Төслийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж	Төсөл хэрэгжих аймаг, сум	Ашигт малтмалын төрөл
2012	Өвөлжөөтийн алтны шороон ордыг ашиглах	Дун-Эрдэнэ ХХК	Дорнод аймгийн Баяндун сум	Алт
2012	Цагаан чулуут хоолой-1 алтны шороон орд ашиглах	Эс Жи Майнинг эрдэс ХХК	Дорнод аймгийн Баяндун сум	Алт
2012	Үүдийн төмрийн хүдрийн орд ашиглах	Дорны хүдэр ХХК	Дорнод аймгийн Булган сум	Төмөр
2013	Баян тойргийн элсний орд ашиглах	Тоуу ХХК	Дорнод аймгийн Хэрлэн сум	Элс
2013	Цагаан чулуут худаг” алтны шороон орд	Жамп алт ХХК	Дорнод аймгийн Баяндун сум	Алт
2013	Тосон уул XIX тамсаг XXI талбайд газрын тос олборлох	Петрочайна Дачин ТамсагХХК	Дорнод аймгийн Матад сум	Газрын тос
2013	тосон уул XIX талбайд газрын тос олборлох	Петрочайна Дачин ТамсагХХК	Дорнод аймгийн Матад сум	Газрын тос
2013	Тамсаг XXI талбайд газрын тос олборлох	Петрочайна Дачин ТамсагХХК	Дорнод аймгийн Матад сум	Газрын тос
2013	Ганзагат” нэртэй хайлуур жоншны орд	Баян уудам тал ХХК	Дорнод аймгийн Булган сум	Жонш
2013	Нүүрсний орд ашиглах	Адуунчулуун ХК	Дорнод аймгийн Хэрлэн сум	Нүүрс
2013	Нүүрсний орд ашиглах	Найнг ХХК	Дорнод аймгийн Хэрлэн сум	Нүүрс
2014	Рашаантын хөндийн -1 алтны шороон орд ашиглах	Голдентайга ХХК	Дорнод аймгийн Баяндун сум	Алт
2014	Ширэн-Овоо төмрийн хүдрийн орд ашиглах	Зэст-Өндөр ХХК	Дорнод аймгийн Халх гол сум	Төмөр
2014	Хайлуур жоншны орд ашиглах	СПЕК ХХК	Дорнод аймгийн Матад сум	Жонш
2015	Сүмтийн хоолой алтны шороон орд ашиглах	Гоулдэнын Монголиа ХХК	Дорнод аймгийн Баяндун сум	Алт
2015	Хар сэврэнгийн алтны орд	Хөх дэл инвест ХХК	Дорнод аймгийн Матад сум	Алт

2015	Эрдэнэ толгойн төмөр холимог металлын ордоос хүдэр олборлох	Хар мөрөн монгол ХХК	Дорнод аймгийн Баян уул сум	Төмөр
2015	Улаан холимог металлын орд ашиглах	Шинь шинь ХХК	Дорнод аймгийн Дашбалбар сум	Холимог метал

2.9. Дундговь аймаг

Дундговь аймгийн нутаг дэвсгэрийн 0,7 хувийг буюу 1126,6 мян.га талбай бүхий ашигт малтмалын ашиглалтын 85, хайгуулын 147, нийт 232 тусгай зөвшөөрөл 2016 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр бүртгэлтэй байна⁹. Тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулах жоншны 9, төмрийн 3, нүүрсний 4, гөлтгөнийн 3, нийт 19 төсөл (хүснэгт 18)-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2012-2016 оны хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох нэгжээр батлагдаж Баянжаргалан, Цагаандэлгэр, Гурвансайхан, Өндөршил, Дэлгэрхангай, Говь-Угтаал сумд (зураг 9)-ын нутагт хэрэгжсэн байна.

Зураг 9. Дундговь аймаг



Хүснэгт 17. Хуралдааны ирц / Дундговь аймаг/

№	ҮСХорооны 2015 оны тайланд туссан нийт өрхийн дундаж тоо	БИНХурлын ирцийн дундаж тоо /хуралдааны тэмдэглэлд тусгагдсанаар/	Хуралдаан хүчин төгөлдөр болох хуулиар тогтоосон шалгуур үзүүлэлт
1	319	54	80

Иргэдийн нийтийн хуралд оролцогчдоос гаргасан саналууд:

1. Гүний худаг гаргаж өгөх
2. Сургууль барьж өгнө гэсэн амлалт ажил хэрэг болгох
3. Засмал зам тавих
4. Үйл ажиллагааг нь дэмжихгүй
5. Орон нутгаас тодорхой тооны ажилтан авч ажиллуулах
6. Нөхөн сэргээлт чанартай сайн хийх
7. Элсний нүүдэл сааруулах зорилгоор, мод суулгац тарих
8. Орон нутгаас ажилтан авах
9. Гөлтгөнө ялгах ажлын хөлсийг нэмэгдүүлэх
10. Сум багийн хөгжилд хандив өгөх
11. Дүйцүүлэн нөхөн сэргээлт хийх
12. Уурхайн нөлөөлөлд өртөж байгаа иргэдэд дэмжлэг үзүүлэх

⁹ Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны жилийн эцсийн тайлан мэдээ, www.mram.gov.mn

13. Сум багийн хөгжилд хандив өгөх
14. Дүйцүүлэн нөхөн сэргээлт хийх
15. Уурхайн нөлөөлөлд өртөж байгаа иргэдэд дэмжлэг үзүүлэх
16. Гүний худаг гаргаж өгөх
17. Усны нарийн шинжилгээг малчдын төлөөлөлтэй хийх
2013	Хөшөөтийн нүүрсний уурхайн нүүрс хуурай баяжуулах үйлдвэр	Моэнко ХХк	Ховд аймгийн Дарви сум	Нүүрс
2015	Хөшөөтийн нүүрсний уурхай	Моэнко ХХК	Ховд аймгийн Дарви сум	Нүүрс
2016	Төгөлийн алтны шороон орд ашиглах	Идеал системс ХХК	Ховд аймгийн Мөст сум	Алт

2.20. Хөвсгөл аймаг

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрийн 0,1 хувийг буюу 111,0 мян.га талбай бүхий ашигт малтмалын ашиглалтын 18, хайгуулын 17, нийт 35 тусгай зөвшөөрөл 2016 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр бүртгэлтэй байна²⁰. Тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулах нүүрсний орд ашиглах 1 төсөл (хүснэгт 40)-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2012-2016 оны хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох нэгжээр батлагдаж Цэцэрлэг (зураг 20)-ын нутагт хэрэгжсэн байна.

Зураг 20. Хөвсгөл аймаг



Хүснэгт 39. Хуралдааны ирц / Хөвсгөл аймаг/

№	ҮСХорооны 2015 оны тайланд туссан нийт өрхийн дундаж тоо	БИНХурлын ирцийн дундаж тоо /хуралдааны тэмдэглэлд тусгагдсанаар/	Хуралдаан хүчин төгөлдөр болох хуулиар тогтоосон шалгуур үзүүлэлт
1	186	5	46

Иргэдийн нийтийн хуралд оролцогчдоос гаргасан саналууд:

1. БО төлөвлөгөөг сайтар даган мөрдөх

Хүснэгт 40. Уул уурхайн төсөл 2012-2016


Төслийн огноо	Төслийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж	Төсөл хэрэгжих аймаг, сум	Ашигт малтмал
2016	Могойн голын нүүрсний ордыг ашиглах	Могойн гол ХК	Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сум	Нүүрс

²⁰ Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны жилийн эцсийн тайлан мэдээ, www.mram.gov.mn

2.21. Хэнтий аймаг

Хэнтий аймгийн нутаг дэвсгэрийн 0,4 хувийг буюу 591,5 мян.га талбай бүхий ашигт малтмалын ашиглалтын 103, хайгуулын 173, нийт 276 тусгай зөвшөөрөл 2016 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр бүртгэлтэй байна²¹. Тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулах алтны орд ашиглах 6, жоншны 9, нүүрсний 1, төмрийн 1, цагаан тугалганы 1 нийт 18 төсөл (хүснэгт 42)-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2012-2016 оны хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох нэгжээр батлагдаж Батноров, Батширээт, Баян-Овоо, Бор-Өндөр, Дархан, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Хэрлэн, Цэнхэрмандал сумд (зураг 21)-ын нутагт хэрэгжсэн байна.

Зураг 21. Хэнтий аймаг



Хүснэгт 41. Хуралдааны ирц / Хөвсгөл аймаг/

№	ҮСХорооны 2015 оны тайланд туссан нийт өрхийн дундаж тоо	БИНХурлын ирцийн дундаж тоо /хуралдааны тэмдэглэлд тусгагдсанаар/	Хуралдаан хүчин төгөлдөр болох хуулиар тогтоосон шалгуур үзүүлэлт
1	303	31	75

Иргэдийн нийтийн хуралд оролцогчдоос гаргасан саналууд:

1. Хаягдлын нуурыг чанартай байгаль орчинд халгүй хийх

²¹ Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны жилийн эцсийн тайлан мэдээ, www.mram.gov.mn

2. *ИНХ-с асууя манай баг 200 гаруй хүнтэй одоо ирсэн иргэд иргэдийн төлөөлөл болж чадах уу*
3. *Нөхөн сэргээлт чанартай хийх*
4. *Орон нутагт бодитой хөрөнгө оруулалт хийх*
5. *Багийн соёлын төв барихад дэмжлэг үзүүлэх*
6. *Уурхайн эргэн тойронд мод тарих*
7. *Орон нутгаас ажилтан авах*
8. *Мах, сүү, цагаан идээ авч байх*
9. *Орон нутгаас ажилтан авах*
10. *Уурхайтай ойр байгаа малчин өрхийн өвөлжөөний асуудлыг шийдвэрлэх, нүүлгэх бол зардлыг хариуцах*
11. *Орон нутагт бодитой ажил хийж гүйцэтгэх*
12. *Гүний худаг шинээр гаргах*
13. *Орон нутгаас ажилтан авах*
14. *Нөхөн сэргээлт чанартай хийх*
15. *Усны нөөцөд сөргөөр нөлөөлөхгүй хэмжээнд ус ашиглах*
16. *Тоосжилт бууруулах тал дээр анхаарч ажиллах*

Хүснэгт 42. Уул уурхайн төсөл 2012-2016

2. Төслийн огноо	3. Төслийн нэр	4. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж	6. Төсөл хэрэгжих аймаг, сум	7. Ашигт малтмалын төрөл
2012	Хайлуур жоншны орд ашиглах	Маль Флюорит ХХК	Хэнтий аймгийн Батноров сум	Жонш
2012	Модотын цагаан тугалганы техноген ордыг ашиглах	Эрдэнэ линк ХХК	Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум	Цагаан тугалга
2012	Алтны үндсэн орд ашиглах	Гутайн даваа ХХК	Хэнтий аймгийн Батширээт сум	Алт
2012	Чандгана талын ил уурхай	Чандгана Коул ХХК	Хэнтий аймгийн Мөрөн сум	Нүүрс
2012	Уртын хөндийн алтны шороон ордыг ашиглах	Дацантрейд ХХК	Хэнтий аймгийн Норовлин сум	Алт
2012	Хавтгай-1 жоншны далд орд	Бор-Өндөр уул ХХК	Хэнтий аймаг Батноров сум	Жонш
2012	“Булган уул” хайлуур жоншны ордын 2.3р судлыг далд аргаар ашиглах	ГОК БУЛГАН УУЛ ХХК	Хэнтий аймгийн хэрлэн сум	Жонш
2013	Идэрмэг нэртэй хайлуур жонш ашиглах	ЭБГ ХХК	Хэнтий аймгийн Батноров сум	Жонш
2013	Хүдрийн 9-р биет нэртэй хайлуур жоншны ордын төсөл	Баян тэгш импекс	Хэнтий аймгийн Дархан сум	Жонш
2014	Хайлуур жоншны 16-1 хүдрийн биет ашиглах	Си ЭМ Кэй Ай ХХК	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум	Жонш

2014	Өвөлжөөний эх ам-ны алтны шороон орд ашиглах	Жи Эф Си ХХК	Хэнтий аймгийн Жаргалтхаан сум	Алт
2015	Цагаан давааны алтны шороон орд	Ирээдүйн алтан шонхор ХХК	Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум	Алт
2015	Ургын хөндийн алтны шороон ордыг ашиглах	Дацан трейд ХХК	Хэнтий аймгийн Норовлин сум	Алт
2015	Булган уул хайлуур жоншны ордыг 1-р судлыг далд аргаар ашиглах	Ди Жи Ти Энд Эм ХХК	Хэнтий аймгийн Хэрлэн сум	Жонш
2015	Булган уул хайлуур жоншны ордын 2,3-р судлыг далд аргаар ашиглах	Гок Булган уул ХХК	Хэнтий аймгийн Хэрлэн сум	Жонш
2015	Дожир хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах	Ханшашир ХХК	Хэнтий аймгийн Баян овоо сум	Жонш
2015	Боргилт овоо төмрийн хүдрийн орд ашиглах	Лут чулуу ХХК	Хэнтий аймгийн Дархан сум	Төмөр
2016	Гутайн алтны шороон ордыг ашиглах	Айвуун тэс ХХК	Хэнтий аймгийн Батширээт сум	Алт

Гурав. Дүгнэлт, зөвлөмж


“Багийн нийтийн хурлаар байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэлэлцүүлсэн байдалд үнэлгээ” хийх зөвлөх ажлын хүрээнд, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны архивд хадгалагдаж байгаа 2012-2016 онуудад хэрэгжсэн уул уурхайн төслүүдийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний 297 тайланг бусад 2083 тайлангаас ялган авч судалж үзлээ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь хэсэгт төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл гэж заасны дагуу 297 төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан тайланд авагдсан захиргаа, нийтийн хурлын санал, тэмдэглэл нийт 1185 нүүр материалыг татан авч баримт бичгийн, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах аргуудыг хэрэглэн хараат бус, бие даасан, баримтат үндэслэх зарчмыг баримтлан дараах шалгуур үзүүлэлтүүдээр энэхүү зөвлөх ажлын дүгнэлтийг гаргав.

3.1.1. Төсөл хэрэгжсэн аймаг, сум

Ашигт малтмал олборлох уул уурхайн 297 төсөл Улаанбаатар хотын 5 дүүрэг, 20 аймгийн 105 сумдын /зураг 22/ нутаг дэвсгэрт 2012-2016 оны хооронд хэрэгжиж, энэ хугацаанд хамгийн олон буюу 29 төсөл Төв аймгийн Заамар суманд, хамгийн бага буюу аймгийн хэмжээнд 1 төсөл Завхан аймгийн Дөрвөлжин сум, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд тус тус үйл ажиллагаа явуулсан байна.

Зураг 22. Уул уурхайн төслийн тоо /2012-2016/



3.1.2. Ашигт малтмалын төрөл

Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны 12 дугаар сарын статистик мэдээнд гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүн болох төмрийн хүдэр, баяжмал 6085 мян.тн, зэсийн баяжмал 1562 мян.тн, цайрын хүдэр, баяжмал 126 мян.тн, боловсруулаагүй, хагас боловсруулсан алт 1916,85 кг, нүүрс 3612,7 мян.тн тус тус экспортод гаргасан талаар мэдээлсэн байна²². Судалгаанд хамаарах хугацаанд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан нь батлагдсан уул уурхайн 297 төслийн хүрээнд нийт 23 нэр төрлийн ашигт малтмал олборлосноос /график 4/ алт, нүүрс, жонш, төмөр болон барилгын материал дангаараа 86.8 хувийг бүрдүүлж байна.

²² www.mram.gov.mn

График 4. Ашиглаж эхэлсэн ордуудын ашигт малтмалын төрөл




Эх сурвалж: БОАЖЯам

Дээрх ашигт малтмалыг манай улс олборлож, ашиглаж байсан туршлагатай, экспортын гол нэрийн бүтээгдэхүүн байх бөгөөд харин уул уурхай, байгаль орчны салбарт чухал бөгөөд хариуцлагатай шинэ хуудас болж ураны төсөл Дорнод аймгийн Улаанбадрах сумын Зөөвч овоо нэртэй газарт 2015 оноос “Кожеговь” ХХК хэрэгжүүлж эхэлсэн байна.

3.1.3. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргааны санал

Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь хэсэгт төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргааны саналыг авахаар тусгасан. Хуульд заасан захиргаа гэдэгт ямар байгууллага эсвэл албан тушаалтыг хэлсэн нь тодорхойгүй байгаа байдлаас үүдэн аж ахуйн нэгжүүд янз янзаар хуулийг ойлгож, хэрэглэсэн байна /график 5/.

График 5. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргааны саналыг гаргасан субъектүүд



Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний төслийг хэлэлцээд гарсан саналын 82 хувийг Иргэдийн нийтийн хурлын дарга болон Сумын Засаг дарга нар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлсэн бол үлдсэн хэсгийг Сумын Иргэдийн Төлөөлөгчийн хурлын дарга, Дүүргийн Засаг дарга, Багийн Засаг дарга, Аймгийн Байгаль орчны газар, Аймгийн Засаг даргын тамгын газар тус тус гаргасан байна.


Орон нутгаас ирүүлсэн саналд холбогдох хуулийн зүйл заалтыг зааж бичих явдал учир дутагдалтай байгаа нь нийт ирсэн саналын зөвхөн 24.4 хувьд эрх зүйн үндэслэлийг дурдсан байдлаас харагдаж байна.

Мөн дээрх саналуудыг төслийн тайланд хавсаргахдаа дийлэнх тохиолдолд буюу 86.6 хувьд нь дан хуулбар эсвэл скайнардсан байдлаар /зураг 23/ авагдсан нь албан хэрэг хөтлөлтийн шаардлага хангахгүйгээс гадна, үнэн зөв эсэхэд эргэлзээ төрүүлж байгааг /хавсралт 5.2/ тэмдэглэх нь зүйтэй.

Багийн нийтийн хурлыг зохион байгуулсан газрууд нь харилцан адилгүй боловч 51.1 хувийг Сумын Иргэний танхим болон Багийн соёлын төвд ээлжит, ээлжит бус хуралдаан болсон байна. Мөн малчин өрхийн гэрт, уурхайн кеймпд, сургуулийн спорт зааланд зэрэг бусад газруудад 19.1 хувь нь хуралдсан байна.

Түүнчлэн, Иргэдийн Нийтийн Хурлын даргын өрөөнд нийт хурлын 8.4 хувь нь хуралдсан бол 41 удаагийн хурал буюу нийт хурлын 13.8 хувь хаана хуралдсан нь тодорхойгүй байгаа нь анхаарал татаж байна /график 6/.

График 6. Багийн нийтийн хурал болсон газрууд



3.1.4. Багийн Нийтийн Хурлын ирц

Монгол улсын нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10-т Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно гэж заасан байна.


Судалгаанд хамрагдсан уул уурхайн төслүүдийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд авагдсан Багийн нийтийн хурлын тэмдэглэлд 5-160 иргэн хуралдаанд оролцсон гэж тусгасан нь дунджаар 53 иргэн хурал хүрэлцэн ирсэн байна. Харин Үндэсний Статистикийн Хорооны тайлан мэдээнд үндэслэн холбогдох хуулийн шаардлагын дагуу нягталж үзэхэд, дунджаар 67 иргэн хуралд хүрэлцэн ирсэн бол хурлын шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно.

Мөн Багийн нийтийн хурлын тэмдэглэлд зөвхөн тухайн баг, сумын тэргүүлэгч оролцож, санал шийдвэр гаргасан тохиолдол нийт тэмдэглэлийн 26.4 хувийг эзэлж байгаад анхаарахгүй байж болохгүй юм. Учир нь, Монгол улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-д Энэ хуулийн 9.1.1-9.1.3-т заасан Хурлын хуралдааны чөлөө цагт бүрэн эрхийг нь тэдгээрийн Тэргүүлэгчид хэрэгжүүлнэ гэж заасан боловч мөн хуулийн 17.1.8-д иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн нутаг дэвсгэрийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай хүсэлтийг хэлэлцэж саналаа сум, дүүргийн Хуралд уламжлах эрх гагцхүү

баг, хорооны хуралд хадгалагдахаар хуульчилжээ. Иймд дээрх 26.4 хувийн санал, тэмдэглэл одоо мөрдөгдөж байгаа хуулийн хүрэнд хүчин төгөлдөр гэж үзэх боломжгүй юм. Түүнчлэн, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн багийн нийтийн хуралд хэдэн нутгийн иргэд оролцсон нь тодорхойгүй буюу тэмдэглэлд ирцийн талаар огт тусгаагүй байдал 17.8 хувийг эзэлж байна.

Дээрх баримтад үндэслэн ерөнхий байдлаар дүгнэвэл, багийн нийтийн хурлын ирц хуулийн нөхцөл, шаардлагыг хангадаггүй нийтлэг зөрчил, дутагдалтай байна /график 7/.

График 7. Багийн нийтийн хурлын ирцийг, хуулийн шаардлагатай харьцуулж үзэхэд



Судалгааг хийх явцад илэрхий болсон нэг баримт бол, багийн нийтийн хурлын тэмдэглэлд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хэдэн тооны иргэд оролцсон нь тоогоор илэрхийлэгдэж байхаас хуралд хэн гэдэг байнгын оршин суугч оролцсон талаар үйлдсэн гарын үсэгтэй ирцийн баримт авагдаагүй, эсхүл нэг бичгийн хэвээр иргэдийн нэрсийг бичиж гарын үсэг зурсан, хаана, ямар зорилгоор гарын үсэг зурсан нь тодорхойгүй бичгийн түрүүгүй нотлох баримтын шаардлага хангахгүй байдал нийт тэмдэглэлийн 80 гаруй хувийг эзэлж байгааг цохон тэмдэглэе.

Багийн Нийтийн Хурлын ирцтэй холбоотой энэ бүх асуудлыг дүгнэж үзвэл, хурлын ирц хангалтгүй, хуулийн шаардлага хангахгүй байхад хуралдаан явуулдаг байдал түгээмэл, мөн хуулиар эрх олгогдоогүй этгээд буюу Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчид шийдвэр гаргадаг, албан хэрэг хөтлөлтийн энгийн шаардлага хангаагүй тэмдэглэл үйлддэг явдлыг засаж залруулан, хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.1.5. Багийн Нийтийн Хурлаас гарсан санал, хүсэлт

Төслийн нөлөөлөлд шууд ба шууд бус хэлбэрээр өртсөн болон өртөж болзошгүй тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэдээс Нийтийн хурлын үеэр гаргасан 372 санал, хүсэлтийг тоймлож үзвэл /график 8/ дараах дүр зураг харагдаж байна.

а. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах чиглэлээр

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад санаачилгатай ажиллах, нөхөн сэргээлтийг цаг тухайд нь чанартай сайн хийх, булгийн эхийг хашиж хамгаалах, бэлчээр доройтохоос сэргийлж, нэг замаар тээвэрлэлт хийх, тоосжилтыг бууруулах, нөхөн сэргээлтэд нутгийн унаган олон наст ургамал суулгах, булаг, шандын эхийг хашиж хамгаалах, тээвэрлэлт хийхдээ зам дээр хог хаяхгүй байх болон уурхайн хог хаягдлыг тогтоосон цэгт стандартын дагуу дарж булах, хортой, аюултай хэрэглэхгүй байх өлийн

цагаан оготно устгахад хамтарч ажиллах зэрэг саналыг давхардсан тоогоор 128 удаа /нийт санал, хүсэлтийн 35 хувь/ багийн нийтийн хуралдааны үеэр хэлсэн байна.

b. Сум, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр

Багийн соёлын төв болон сургуулийн байрыг завсарлах, засмал зам тавих, хүүхдийн цэцэрлэгийн гадна тохижилт, спорт талбай байгуулах, эрчим хүчний сүлжээнд холбогдоход дэмжлэг үзүүлэх, соёлын өв, дурсгалд газрыг хамгаалах, орон нутагт үлдэх бүтээн байгуулалт хийх, орон нутагт тулгарсан асуудалд тусалж үзүүлэх зэрэг санал, хүсэлт давхардсан тоогоор 54 удаа /нийт санал, хүсэлтийн 17 хувь/ гарсан байна.


c. Төслийн нөлөөлөлд өртсөн болон өртөж болзошгүй нутгийн иргэдэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр

Орон нутгаас ажилтан авч ажиллуулах, гүний худаг гаргаж өгөх, сургуулийн хүүхдийн хичээлийн хэрэгсэл авахад дэмжлэг үзүүлэх, орон нутгаас их, дээд сургуульд амжилттай суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төлөх, мал багатай иргэдийг малжуулах, уурхайн ажилчдын хэрэгцээнд мах, сүү, цагаан идээ авч байх, орон нутгаас ажиллаж байгаа иргэдийг тогтвор суурьшилтай ажиллуулах, олборлосон нүүрс болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс нутгийн иргэдэд хөнгөлөлттэй үнээр борлуулах, иргэдийн нөхөрлөл, бичил уурхай эрхлэгчдийг дэмжиж ажиллах зэрэг давхардсан тоогоор 152 удаа /нийт санал, хүсэлтийн 38 хувь/ санал, хүсэлт гаргасныг тэмдэглэлд тусгажээ.

d. Баг, хорооны нийтийн хурлын үеэр гарсан бусад санал, хүсэлт

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэхийг дэмжсэн болон татгалзсан, Багийн ИНХ, БЗД-тай нягт хамтарч ажиллах, жилийн эцэст үйл ажиллагаагаа тогтмол тайлагнадаг байх, уурхайн эдэлбэр газрыг хаших, мал орж унахаас хамгаалах, тээвэрлэлт хийх зам дагуу малын гарц, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, уул уурхайтай ойр гүний худгуудад тогтмол шинжилгээ, хэмжилт хийх, нутгийн иргэдийн санал бодлыг авч байх зэрэг санал, хүсэлт давхардсан тоогоор 48 удаа /нийт санал, хүсэлтийн 10 хувь/ гаргасан байна.

График 8. Багийн Нийтийн Хурлаас гарсан санал, хүсэлт



3.2.Зөвлөмж

3.2.1. Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллагыг захиргааны байгууллага гэж ойлгоно гэж хуульчилсан байна. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8-д заасан нутгийн “захиргааны” санал гэдгийг төсөл хэрэгжүүлэгч болон байгаль орчны үнэлгээ хийх эрх бүхий компани янз бүрээр ойлгож, хэрэгжүүлж байгааг /график 5/ буруутгах боломжгүй, харин төсөл хэрэгжих орон нутгийн захиргаанаас санал авч байгаа өнөөгийн хууль эрх зүйн орчин нь төсөл хэрэгжүүлэгчид хүндрэлтэй, олон шат дамжлага, чирэгдэл учруулж болохоор нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Түүнчлэн асуудлыг хариуцаж санал өгөх албан тушаалтныг тодорхой хуульчлаагүй байдлаас үүдэн тухайн орон нутгийг төлөөлөх эрхгүй этгээд орон нутгийн санал дээр гарыг үсэг зуран байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэх боломж нээлттэй байна.

Монгол Улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч мөн гэж хуульчилсан. Мөн Монгол Улсын нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.м-д нутаг дэвсгэрийнхээ байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн талаар гаргасан сум, дүүргийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах бүрэн эрх сум, дүүргийн Засаг даргад олгогдсон байна.

Орон нутгаас санал авах асуудлыг тухайлан хуульчилсан Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дахь заалтад Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.3-т заасан²³ мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч 30 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ гэж тодорхой зохицуулжээ. Мөн Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т Тухайн сав газарт ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах тусгай зөвшөөрөл олгоход тус сав газрын захиргааны саналыг үндэслэнэ гэж нарийвчлан заасан байдаг.

Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8-д заасан нутгийн захиргааны санал гэдгийг “сум, дүүргийн эсвэл баг, хорооны Засаг даргын санал” гэж өөрчлөн найруулах нь нэг хувилбар байж болно.

Мөн одоо мөрдөгдөж байгаа үнэлгээний хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа зүйл бол багийн нийтийн хурлыг зохион байгуулж, хуралдуулах үүргийг төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, үнэлгээний компанид оногдуулснаас үүдэлтэй байна. Тиймээс, багийн Иргэдийн Нийтийн Хурлын даргыг байгаль орчны нарийвчилсан үнэлгээ болон Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэлэлцүүлэхээр ирүүлснээс хойш 30 хоногийн дотор Багийн нийтийн хурлаар хэлэлцүүлж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ гэж үүрэгжүүлэх өөр нэг хувилбар байна.

3.2.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн шинэчлэн найруулгаар орсон чухал зохицуулалт бол төсөл хэрэгжих орон нутаг, тэр дундаа засаг захиргааны хамгийн анхан шатны нэгж болох баг, хорооны иргэдээс саналыг нь авдаг болсон явдал юм. Энэ зохицуулалтын үйлчлэлээс үүдэн иргэд амьдран сууж байгаа нутаг орондоо хэрэгжих гэж

²³ Ашигт малтмалын тухай хуулийн 19.3-д Энэ хуулийн 19.2.2, 19.2.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн бол төрийн захиргааны байгууллага нь энэ талаар тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд энэ хуулийн 17.1-д заасны дагуу хийгдсэн талбайн зургийг хавсаргана.

байгаа төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн талаар мэдлэг, мэдээлэлтэй, төсөл хэрэгжүүлэгчтэй уулзаж санал, хүсэлтээ хэлэх боломж бүрдсэн байна.

Байгаль орчны багц хуулиуд Улсын Их Хурлаар батлагдаж, мөрдөгдсөн өнгөрсөн 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхэд олон талын хүндрэлтэй асуудлууд тулгарсныг нэг нь иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэлийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд заавал тусгах асуудал юм. Учир нь, Иргэдийн Нийтийн ээлжид хурал нь жилдээ 1-ээс 2 удаа хуралдах тохиолдол их байгаа тул төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний мэргэжлийн байгууллага хурал хүлээж цаг хугацаа, эдийн засгийн хувьд алдагдалд орж хөрөнгө оруулалтаа алдах зэрэг бэрхшээл гарч байна. Судалгаанд хамрагдсан ашигт малтмалын 297 төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд авагдсан иргэдийн нийтийн хурлын тэмдэглэлээс үзэхэд нийт хуралдааны 96 хувь нь ээлжит бус буюу зөвхөн тухайн төслийн асуудлыг хэлэлцэх гэж хуралдсан байна. Ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулах, хуульд заасан хүчинтэй ирцийг бүрдүүлэх асуудал хүндрэлтэй нь судалгааны үр дүнгээр илэрхий болсон. Мөн авто болон төмөр зам, нефть, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын төсөл зэрэг олон аймаг, сум, багийн нутаг дэвсгэрийг хамарч хэрэгждэг төслийн хувьд төслийн нөлөөлөлд өртөх баг бүрээс санал авах боломж хүндрэлтэй, цаг хугацаа их шаардагдах нөхцөл үүсгэж байна.

Дээр дурдагдсан хуулийг нэг мөр хэрэгжүүлэх боломж дутмаг, цаг хугацаа их шаардагдаж байгаа байдлыг өөрчлөхийн тулд: *төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, тэмдэглэлийг* нарийвчилсан үнэлгээний тайланд тусгахаар хуулийн зохицуулалтыг өөрчлөж болох боловч сөрөг тал нь нөлөөлөлд өртөх нутгийн иргэд биш, сумын төвийн хэсэг бүлэг эрх бүхий хүмүүсийн үзэмжээр асуудлыг шийдвэрлэх байдалд хүрч болзошгүй юм.

3.2.3. Одоо мөрдөгдөж байгаа Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох зохицуулалтад иргэдийн нийтийн хурлын *санал* гэж хэлбэржсэн байх бөгөөд Монгол Улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д Хурал хэлэлцсэн асуудлаар *тогтоол* гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн болон баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхын саналаар тус тус батална гэж заасан байх тул өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тогтоол гэж дусгах нь хуульд нийцэх юм.

3.2.4. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн доторх бүрдэл, агуулга, шинэлэг бүтээлч байдал болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар заасан зарим бүрдүүлбэр хангалтгүй буюу шаардлага хангахгүй байна. Тухайлбал, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т заасан Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна гэсэн зохицуулалтын хэрэгжилт тун хангалтгүй байгааг онцгой анхаарах шаардлагатай. Хэрэв одоо өргөн мэдүүлэх гэж байгаа хуулийн өөрчлөлтөөр сум, дүүргийн хурал тогтоол гарган, тэмдэглэл үйлдэж Засаг даргаар дамжуулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх тохиолдолд төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулах нь иргэдийн санал, хүсэлтийг сонсох, төсөл хэрэгжүүлэгч тухайн орон нутагт явуулах үйл ажиллагааг зөв таниулах ач холбогдолтой.

Харин Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаанаас санал авах талаар зохицуулсан хэсэг нь хуулийн давхардал үүсгэх, төсөл хэрэгжүүлэгчид хүндрэл учруулахаар байх тул хасах саналтай байна.

3.2.5. Багийн Нийтийн Хуралд оролцсон ирцийн мэдээнээс хүйс болон насаар ялган харах боломжгүй байсан учир нь ирцийг зөвхөн тоон утгаар тэмдэглэлд тусгасантай холбоотой. Ирцийн мэдээ нь тухайн хурлын шийдвэр хүчин төгөлдөр эсэхийг шийдвэрлэх чухал суурь ойлголт тул тусгайлсан маягтын загвар байгаль орчин, аялал жуучлалын сайдын тушаалаар /2014 оны А-117 дүгээр тушаалд нэмэлт оруулах/ баталж, нийтээр мөрдүүлэх шаардлагатай байна. Ирцийн бүртгэлийн маягтын түрүү хэсэгт Багийн Нийтийн Хурал хаана, хэзээ, ямар төслийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон Байгаль хамгаалах төлөвлөгөөг хэлэлцсэн талаар тодорхой тусгаж, бүрдүүлбэрийг хүснэгт 22-т заасны дагуу боловсруулах саналтай байна.

Хүснэгт 43. Багийн Нийтийн Хурлын Ирцийн бүртгэлийн загвар

Овог нэр	Регистрын дугаар	Утасны дугаар	Дэмжсэн эсэх /гийм, үгүй/	Гарын үсэг
----------	------------------	---------------	---------------------------	------------

Дээрх байдлаар ирцийн бүртгэлийг авдаг болвол хуралд оролцогчдын нас, хүйс, дэмжсэн үгүйг мэдэж болохоос гадна хамгийн чухал нь хурал хуулийн хүчин төгөлдөр болсон эсэхийг тогтоох боломж бүрдэх юм.





3.2.6. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжүүд тайлан боловсруулахдаа Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний аргачлал батлах тухай” арга зүйг баримтлан ажиллах явдал учир дутагдалтай байна. Жишээлбэл, байгаль орчны төлөв байдлыг тодорхойлоход шаардлагатай нэмэлт судалгаа хийх; төслийн үйл ажиллагаа явагдах, түүний нөлөөлөлд өртөж болзошгүй нутаг дэвсгэрийн хил хязгаар-(өндөр нарийвчлалтай GPS, дифференциал GPS, электрон тахеометр г.м сүүлийн үеийн хэмжих багаж, GIS, MapInfo, Erdas, Surfer зэрэг програм хангамж ашиглан)-ыг нарийвчлан тогтоох, зохих хураангуйлалтай газрын зурагт буулгах болон дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг тодорхойлохдоо биологийн олон янз байдлын суурь нөхцөл байдлыг үнэлсний дараагаар дүйцүүлэн хамгаалах экосистемийн төрөл, амьтан, ургамлын зүйл тус бүрээр тодорхойлох зэрэг чухал ач холбогдолтой асуудлууд орхигдох буюу хангалтгүй түвшинд хийгдсэн байгаад анхаарч ажиллах, цаашид үнэлгээний тайлангийн чанарыг эрс сайжруулах, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэлийг эх хувиар, эсхүл баримт бичгийн хуулбар хувийг байгууллагын тэмдгээр баталгаажуулан хавсаргах шаардлагатай байна.

Мөн үнэлгээний тайлангуудын агуулга хооронд адилхан, хуулбарласан байдал нэн түгээмэл, орон нутгийн санал, тэмдэглэлийг дэс дугаарлаж тайланд хавсаргадаггүй байдлаас үүдэн нэг тайланг олон дахин эргүүлж үзэх, холбогдох хэсгийн хайх зэргээс зөвлөх үйлчилгээний ажлын явц удаашрахад хүрч байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Дөрөв. Шинэчлэн найруулах болон нэмэлтээр оруулах эрх зүйн актын төсөл

Жич: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар захиалагч байгууллагын саналын хүрээнд доорхи үзэл баримтлал дээр ажилласан болно/

5.1. Нийтлэг шаардлага хангаж буй санал, тэмдэглэл, ирцийн хуулбар



Баан-Овоо багийн иргэдийн нийтийн хурлын
хуралдааны иршийн бүртгэл

2015 оны 09 сарын 03 өдөр

№	Овоо нэр	Гарын үсэг
1	А. Ганзориг	А. Ганзориг
2	Г. Мөнхсайхан	Г. Мөнхсайхан
3	М. Ямаа	М. Ямаа
4	Э. Мөнхтүвшин	Э. Мөнхтүвшин
5	М. Наран	М. Наран
6	Н. Наранжавбал	Н. Наранжавбал
7	Н. Нарантөвшин	Н. Нарантөвшин
8	А. Чамал-Орвоо	А. Чамал-Орвоо
9	М. Чинзориг	М. Чинзориг
10	Н. Чинзориг	Н. Чинзориг
11	Н. Чинзориг	Н. Чинзориг
12	Р. Чинзориг	Р. Чинзориг
13	Б. Чинзориг	Б. Чинзориг
14	Т. Чинзориг	Т. Чинзориг
15	Д. Чинзориг	Д. Чинзориг
16	С. Чинзориг	С. Чинзориг
17	Н. Чинзориг	Н. Чинзориг
18	А. Чинзориг	А. Чинзориг
19	В. Чинзориг	В. Чинзориг
20	Б. Чинзориг	Б. Чинзориг
21	Г. Чинзориг	Г. Чинзориг
22	Д. Чинзориг	Д. Чинзориг
23	У. Чинзориг	У. Чинзориг
24	С. Чинзориг	С. Чинзориг
25	Я. Чинзориг	Я. Чинзориг
26	Н. Чинзориг	Н. Чинзориг
27	Г. Чинзориг	Г. Чинзориг
28	Д. Чинзориг	Д. Чинзориг
29	У. Чинзориг	У. Чинзориг
30	С. Чинзориг	С. Чинзориг
31	Я. Чинзориг	Я. Чинзориг
32	Н. Чинзориг	Н. Чинзориг
33	Г. Чинзориг	Г. Чинзориг
34	Д. Чинзориг	Д. Чинзориг
35		
36		
37		
38		

**ДОРНОГОВЬ АЙМАГ
САЙХАНДУЛААН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫГ**

Утас: (765) 2-69-01


2015.09.06 № 58

Санал хүргүүлэх тухай

Манай сумын нутаг дахь Үнэгтийн гөлтөнөй ордыг /12169 А/ эзэмшинч "Эрэл" ХХК заавалгаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотгол ажлыг мөрдөхийн байгууллага болох "ЭВ ЭЖ" ХХК-ний тайлантай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид танилцлаа.

Уг тайланд Үнэгтийн гөлтөнөй ордын шинэчилсэн ТЭЗҮ-д /2012/ тусгасан эдийн засгийн үр ашгийн тооцоог үндэслэн уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжийн дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардал түүнтэй дүйцүүлэх арга хэмжээг сум орон нутагт зохион байгуулах талаар мөн уг төслийн нийгэм эдийн засгийн ач холбогдлыг дэлгэрэнгүй харуулсан тайлангийн төслийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 57,1 хувь нь дэмжиж байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 22 дугаар хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.

ДАРГА  **ЭРДЭНЭЖАРГАЛ**


**НАЛАЙХ ДҮҮРЭГ
5 ДУГААР ХОРООНЫ ЗАСАГ ДАРГА**

12790 Улаанбаатар хот, Налайх дүүрэг,
5 дугаар хороо, Нисхийн гудамж
Утас: 5023-6511

2015.05.14 № 61
танай 2015.05.06-ны № 84 -т

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН БҮЙ
ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Г.НЯМДАВАА ТАНАА**

Тус хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Мерсу" ХХК-ны Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлантай танилцаад бидний зүгээс татгалзах зүйлгүй болно.

ЗАСАГ ДАРГА  **Г. ТАЛСТБОЛОР**

5.2. Нийтлэг шаардлага хангахгүй санал, тэмдэглэл, ирцийн хуулбар


СЭРГИЙН ГАЗРААР
ОРХОНГУУЛ СУМЫН БАВИНОТ 2-Р БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН
ТӨГТӨӨЛ

Баянцогт

Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйл, 23-р зүйлийн 12 дахь заалт, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-р заалт болон хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. "Ирмүүн босго" ХХК – ний алтны шороон ордод олборлох төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг нарийвчилсан үнэлгээ хийлгэхийг зөвшөөрсүгэй.
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны улсын байцагч /Ш.Алхбаар /, багийн засаг дарга /Л.Нямдорж/ нарт даалгасугай.
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээгчийн ажлыг иж бүрэн хийж газрын гадаргууг хөрсжүүлэх боломжгүй нөхцөлд хөрс сайжруулах мод, бутлаг сонгон тарих холбогдох хууль дүрмийг мөрдөж ажиллахыг "Ирмүүн босго" ХХК-ий захирал Х.Цогтоо –д даалгасугай.

ДАРГА  Л. ХОРОЛСҮРЭН

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН ОРХОН БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

_____ оны _____-р сарын _____-ны өдөр Дугаар _____ Цэнхэр сум

Хэлэлцсэн нь:

Орхон багийн Иргэдийн нийтийн хурал 2016 оны _____ дүгээр сарын _____-ны өдрийн _____ цагт багийн төвд болов. Хуралд багийн иргэд, малчдыг төлөөлсөн _____ хүн оролцож багийн хурлын ирц 100 хувьтай хуралдлаа.

Хурал нээж багийн Иргэдийн нийтийн хурлын дарга Ч.Галбадрах үг хэлсэн дараа багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг танилцуулав.

Хэлэлцсэн асуудал:

Хурлаар тус багийн нутаг дэвсгэр Бодонтын аманд алтны шороон ордон үйл ажиллагаа явуулах 12004А тоот тусгай зөвшөөрөлтэй "Алтандорнод Монгол" ХХК-ийн хэрэгжүүлэх төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн төслийг тус төсөл хэрэгжих багийн нутаг дэвсгэрт амьдардаг малчид, иргэдээр хэлэлцүүлж санал бодлыг сонсох асуудлыг эхэлж хэлэлцүүлээ.


Төсөл хэрэгжүүлэгч уул уурхайн компанийн төлөөлөгчид байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний талаар нутгийн иргэдэд тодорхой тайлбарлан танилцуулж, орон нутгийн иргэд, малчдын асуусан асуултаудад хариулав.

Тус төслийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан тухайн төсөл хэрэгжих орчны байгаль орчны төлөв байдал, төслийн зүгээс байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах, багасгах, арилгах арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хяналт шилжилгээний хөтөлбөр, нөхөн сэргээгчийн төлөвлөгөө зэргийн талаар дэлгэрэнгүй тайлбар өглөө.

Үнэлгээтэй холбогдуулж нутагт уул уурхайн төсөл хэрэгжүүлэхэд шинэ техник технологи нэвтрүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад санаачилгатай ажиллах талаар зөвлөмж өглөө.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Багийн Иргэдийн нийтийн хуралд оролцсон иргэд, малчдын 100 хувийн санлаар "Алтандорнод Монгол" ХХК-ийн 12004А тоот тусгай зөвшөөрөл бүхий Бодонтын амны алтны шороон орд төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн төслийг дэмжиж, энэ тухай багийн иргэдийн нийтийн хурлын тогтоол гаргах нь зүйтэй гэж үзэв.

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРЛЫН ДАРГА  Ч. ГАЛБАДРАХ,
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА 1

СУХБААТАР АЙМГИЙН УУЛБАЯН СУМЫН ЖАВХЛАНТ
БАГИЙН ОЛОН НИЙТИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016.03.16

САНЛАЛ ДЭМЖИХ ТУХАЙ

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Жавхлантаг багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй "Сунхунголд" ХХК-ны оруулсан асуудлыг хэлэлцээд, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн багийн иргэдийн нийтийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. "Сунхунголд" ХХК-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хангалттай хэмээн үзэж дэмжсүгэй.
2. Орчны тоосжилт, байгаль орчныг бохирдоос хамгаалах, хариуцлагатай уул уурхайн чиг үүргийг биелүүлэх, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг "Сунхунголд" ХХК-д үүрэг болгосугай.

БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН
ДАРГА  Г. ГАНЧИМЭГ


ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН
ХОЕР ДУГААР БАГИЙН ИРГЭДИЙН
НИЙТИЙН ХУРЛЫН ТОГТООЛ





_____ он _____ сар _____ өдөр Дугаар _____ ХАШААТ.

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалтыг үндэслэн багийн Иргэдийн нийтийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Тус багийн нутгийн Ширээ уул-2 нэртэй газарт гөлтгөнө олборлох үйл ажиллагаа явуулах ашиглалтын талбайдаа БОНБН-ын үнэлгээ хийлгэхийг зөвшөөрсүгэй.
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга, багийн нийт иргэдэд үүрэг болгосугай.
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай төлөвлөөний дагуу нөхөн сэргээлт хийж, газрын гадаргууг хөрсжүүлэх, сайжруулах, олон салаа зам гаргахгүй байх арга хэмжээ авч багийн иргэдтэй хамтарч ажиллахыг "Түмэн тал" ХХК, /Н.Нансал/-д даалгасугай.

БАГИЙН ИНХ-ЫН ДАРГА  Н. БАЯСГАЛАН



5.3. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн жагсаалт

